



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### II ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 09.00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлагын танхим”-аас 86 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгев.

#### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

2. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Онцгой байдлын өрөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:

1.1. Засгийн газрын 2021 оны 385 дугаар тогтоолоор гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд (энэ тэмдэглэлийн 2.1-т тусгайлан зааснаас бусад бүх аймаг, сумдад) цуцлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт, хүн амын дархлаажуулалтад хамрагдсан байдал зэргийг харгалзан үзэж "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам"-д заасан халдварын тархалтын "Шар түвшин"-д 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд шилжих, энэ талаар Улсын онцгой комиссын тогтоол гаргах;

Хоёр. Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд аймгийн Засаг дарга нарт:

2.1. Хилийн боомтын орчимд коронавируст халдварын тархалт нэмэгдэж экспорт, импортын үйл ажиллагаа тасалдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Булган, Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн, Цагааннуур, Боршоо, Сүхбаатар, Алтанбулаг, Эрээнцав хилийн боомт байрлаж буй нутаг дэвсгэрт гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоож, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Гурав. Гадаад харилцааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг, Зам, тээверийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Гаалийн өрөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дэд дарга Д.Уранзаяа нарт:

3.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан шинэ хувилбарын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тогтмол бүрдүүлж, хяналт тавьж ажиллах;

Дөрөв. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Улсын хэмжээнд "Өндөржүүлсэн бэлэн зэрэг"-т шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж байгаатай холбогдуулан "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг хариу арга хэмжээ, тандалт, эмнэлгийн тусламж үйлчилгээнд доголдол үүсэх, хариуцлага, хяналт сулрах зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

4.2. Гамшигаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг бүх шатанд хангуулах, гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх;

Тав. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн, Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт :

5.1. Бүх шатны боловсролын байгууллагын орчинд халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, багш, сургууль, цэцэрлэгийн захиргаа болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтуудын үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэл хяналт тавьж ажиллах;

**Зургаа. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн, Б.Бат-Эрдэнэ, Онцгой байдлын өрөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

**6.1. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэд олон нийтэд, тогтмол мэдээлэл сээрэмжлүүлэг хүргэх;**

**6.2. Цаг уурын байгууллагаас ирүүлсэн мэдээллээр хаврын саруудад ялангуяа нутгийн зүүн хагаст олон жилийн дунджаас дулаан, хур тунадас бага, хурайшилт их, салхи шуургатай байх тул болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, Улсын онцгой комиссын 2022 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах;**

**6.3. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж үерийн эрсдэл бүхий газар айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийг нүүлгэн шилжүүлэх;**

**6.4. Тээврийн хэрэгслийн жолооч, малчид, иргэдэд гүүр, гарамгүй газраар гол, мөрөн гатлахгүй байх, анхаарал болгоомжтой зорчих талаар анхааруулга, сээрэмжлүүлэг тогтмол хүргэх, мөсөн дээгүүр зорчих, тээвэр хийхийг хориглох;**

**6.5. Үерийн хамгаалалтын далан, зам, талбайн ус зайлцуулах зориулалттай инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулах, далан, суваг, шуудууны цэвэрлэгээг хийх;**

**Долоо. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн 3.Мэндсайхан, Мал, эмнэлгийн өрөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

**7.1. Малын гоц халдварт шүлхий өвчний тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;**

**Найм. Улсын онцгой комиссын гишүүд, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

**8.1. Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штаб болон аймаг, нийслэл, сумдын шуурхай штабуудын хэвийн, тасралтгүй үйл ажиллагагааг үргэлжлүүлж, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллах;**

**Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт даалгах.**

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

2024.08.16